



ДУНДГОВЬ АЙМГИЙН
УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/01

Мандалговь

Уламжлалт анагаах ухааны нэгдсэн
эмнэлгийн бүтэц орон тоог шинэчлэн
батлах тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9 дэх хэсэг, Монголын уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5700:2020 стандарт, Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 01 сарын 15-ны өдрийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай А/06 дугаартай тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн бүтцийг нэгдүгээр, орон тоог хоёрдугаар, ажилчдын цалингийн сүлжээ, шатлал, цалингийн нэмэгдлүүдийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан бүтэц, орон тоогоор цалингийн санд багтаан цалинжуулахыг нягтлан бодогч(Э.Уугандаваа)-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2023 оны 01 сарын 13-ны өдрийн "Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" А/01 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Х.ЧИРЧИНСҮРЭН

Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг /26/

Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн даргын 2024 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн А/01 тоот тушаалын нэгдүгээр хавсралт




Дэмжих үйлчилгээ /10/

- Захиргаа, санхүү, аж ахуй хангамж /3/
- Эмнэлгийн тоног төхөөрөмж, инженер
- Мэдээлэл технологи, харилцаа холбоо
- Ариутгал халдваргүйтгэлийн үйлчилгээ /1/
- Угаалга цэвэрлэгээ /2/
- Түргэн тусламж, автомашины үйлчилгээ /1/
- Хоол үйлдвэрлэл, Шим тэжээлийн үйлчилгээ /1/
- Эмнэлгийн хог хаягдал
- Эмнэлгийн бүртгэл мэдээлэл, даатгал /1/
- Хүний нөөц, архив бичиг хэрэг /1/

Эмнэлгийн тусламж үйлчилгээ /16/

- УАУ-ны мэргэшсэн тусламж үйлчилгээ /6/
- Эм зүйн тусламж үйлчилгээ/1/
- Цус сэлбэлт судлалын тусламж үйлчилгээ
- Сэргээн засах тусламж үйлчилгээ
- Эмгэг судлалын тусламж үйлчилгээ
- Яаралтай тусламж үйлчилгээ
- Сувилахуйн тусламж үйлчилгээ /8/
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ /1/
- Чанар, аюулгүй байдлын алба
- Халдварын сэргийлэлт хяналтын алба
- Ес зүйн хороо

Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн
даргын 2024 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн
А/аг. тоот тушаалын хоёрдугаар хавсралт



Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн орон тоо 1-НД0003

№	Албан тушаал	Орон тоо
1	Ерөнхий эмч	1
2	Тасгийн эрхлэгч	1
3	Зөвлөх эмч	1
4	Тасгийн уламжлалт анагаах ухааны их эмч	2
5	Амбулаторийн үзлэгийн уламжлалт анагаах ухааны их эмч	1
6	Өдрийн эмчилгээний уламжлалт анагаах ухааны их эмч	1
7	Ахлах сувилагч	1
8	Өдрийн эмчилгээний сувилагч	2
9	Ээлжийн сувилагч, бага эмч	4
10	Туслах сувилагч	1
11	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан	1
12	Эм зүйч	1
13	Бүртгэл мэдээлэл, эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтан	1
14	Нягтлан бодогч	1
15	Хүний нөөц, архив бичиг хэргийн ажилтан	1
16	Нярав	1
17	Жолооч, сантехникч	1
18	Тогооч	1
19	Ариутгагч	1
20	Үйлчилгээний ажилтан	2
		26